



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Шилүүстэй сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/180/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК -Ахлах аудитор: Б.Дагвасүрэн

Утас: 99014227

Цахим хаяг: b.dagvaa1000@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.17 № 121

Танай _____ -ны № _____ -т

ШИЛҮҮСТЭЙ СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ц. БЯМБАСҮРЭН-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шилүүстэй сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шилүүстэй сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Шилүүстэй сумын Хүүхдийн цэцэрлэгт Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 11,348.5 мянган төгрөгийн 4 ширхэг зөөврийн компьютер, сумын 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд, төгсөгчдөөс 8,349.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, 10,050.1 мянган төгрөгийн биеийн тамирын сургалтын хэрэглэгдэхүүн, УИХ-ын гишүүн Ц.Цэрэнпунцагаас 8,019.7 мянган төгрөгийн гадна тоглоомын талбайн иж бүрдэл, сумын ЗДТГ-аас 6,363.6 мянган төгрөгийн 2 ширхэг зөөврийн компьютер, принтер, нийт 44,131.8 мянган төгрөгийн хөрөнгө, бараа материал ирснийг орлогод авч холбогдох данс бүртгэлд тусгасан байна. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 17 нэр төрлийн 9,004.4 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлүүлэхээр аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Шилүүстэй сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар эд хариуцагчийн бараа материалын тайлан эмх цэгцгүй, хангалтгүй, тогоочийн хоолны цэс баримтанд үдэгдээгүй, хоолны норм, нормативыг сар бүр хянаж зарцуулаагүйгээс тайлангаар гарсан хоолны зарцуулалтын хэмжээ нь цэцэрлэгийн хүүхдийн хоолны нормативт зардлаас зөрж, 01, 09 дүгээр саруудад 154.7 мянган төгрөгөөр дутуу, 02, 12 дугаар саруудад 489.3 мянган төгрөгөөр илүү, нийт 644.1 мянган төгрөгийн зерчил байна.

Бусад асуудлын хэсэг

Шилүүстэй сумын Хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 50 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэл 97.6 хувьтай үнэлэгдсэн байна. Тус цэцэрлэг нь эрхлэгчийн 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/10 дугаар тушаалаар аж ахуйн болон бусад хангамжийн 2,583.5 мянган төгрөгийн бараа материалыг акталж, устгасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д. БАТ-УНДРАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	76,300,777.10	94,736,272.55
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	35,660,811.06	45,849,348.51
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	35,660,811.06	45,849,348.51
3121	Төгрөг	35,660,811.06	45,849,348.51
31211	Төрийн сангийн харилцах	35,660,811.06	45,849,348.51
314	Замд яваа мөнгөн хөрөнгө		
33	АВЛАГА		
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ	40,639,966.04	48,886,924.04
351	Түүхий эд материал	1,325,000.00	1,325,000.00
3513	Эм боох материал	1,325,000.00	1,325,000.00
354	Хангамжийн материал	39,314,966.04	47,561,924.04
3541	Бичиг хэргийн материал	255,000.00	255,000.00
3542	Аж ахуйн материал	17,948,500.00	18,583,700.00
3546	Хүнсний материал	6,939,062.00	4,769,260.00
3547	Бусад хангамжийн материал	14,172,404.04	23,953,964.04
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,395,941,083.17	1,391,997,197.01
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,395,941,083.17	1,391,997,197.01
392	Биет хөрөнгө	1,389,348,083.17	1,385,734,197.01
39201	Барилга, байгууламж, өрөн сууц	1,572,007,380.00	1,580,027,080.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-230,429,465.28	-254,989,325.36
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	60,567,657.92	86,629,647.92
39206	Хуримтлагдсан элэгдэл	-36,076,997.31	-46,163,361.39
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,456,870.32	17,456,870.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,543,409.17	-10,976,670.53
39214	Бусад үндсэн хөрөнгө	32,799,577.00	32,799,577.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-19,533,401.99	-21,149,492.63
39217	Ном	2,099,871.68	2,099,871.68
393	Биет бус хөрөнгө	6,593,000.00	6,263,000.00
39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,155,000.00	-1,485,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,098,000.00	6,098,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,472,241,860.27	1,486,733,469.56
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		707,450.63
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		707,450.63
413	Өглөг		707,450.63
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		707,450.63
414	Урьдчилж орсон орлого		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		

422	Урт хугацаат зээл		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,472,241,860.27	1,486,026,018.93
51	Засгийн газрын хувь оролцоо	1,472,241,860.27	1,486,026,018.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	45,018,465.80	45,018,465.80
51101	Өмч: - төрийн	45,018,465.80	45,018,465.80
512	Хуримтлагдсан үр дүн	1,332,225,720.47	1,346,009,879.13
5121	Өмнөх үеийн үр дүн	1,332,225,720.47	1,332,225,720.47
5122	Тайлант үеийн үр дүн		13,784,158.66
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	94,997,674.00	94,997,674.00
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,472,241,860.27	1,486,733,469.56

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	428,273,794.92	607,450,540.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,527,994.92	45,407,040.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,527,994.92	45,407,040.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,000.00	105,000.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	105,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	10,155,609.92	34,081,690.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,337,385.00	11,220,350.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	415,745,800.00	562,043,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	365,860,700.00	504,184,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	365,860,700.00	504,184,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	49,885,100.00	57,858,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49,885,100.00	57,858,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	416,869,646.78	593,666,381.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	416,869,646.78	593,666,381.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	416,821,150.85	593,666,381.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	254,446,713.24	394,614,206.80
210101	Үндсэн цалин	178,225,733.80	265,081,244.47
210102	Нэмэгдэл	66,785,883.10	117,741,317.93
210104	Урамшуулал	9,435,096.34	11,791,644.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,855,238.54	50,501,785.38
210201	Тэтгэврийн даатгал	21,710,178.60	34,662,928.50
210202	Тэтгэмжийн даатгал	2,554,073.93	3,931,967.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,025,919.13	1,966,183.81
210204	Ажилгүйдлийн даатгал	500,819.00	1,966,183.81
210205	Эрүүл мэндийн даатгал	5,064,247.88	7,974,522.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,883,604.07	56,525,300.00
210301	Гэрэл, цахилгаан	4,746,224.07	4,038,053.92

210302	Түлш, халаалт	42,720,480.00	51,264,576.00
210303	Цэвэр, бохир ус	1,416,900.00	1,222,670.08
2104	Хангамж, бараа материалын зардал	5,218,068.00	6,463,695.00
210401	Бичиг хэрэг	1,608,600.00	454,650.00
210402	Тээвэр, шатахуун	1,368,368.00	1,290,405.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	540,000.00	480,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	555,000.00	660,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,146,100.00	3,578,640.00
2105	Нормативт зардал	36,743,984.00	36,752,518.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,019,000.00	
210502	Хоол, хүнс	35,724,984.00	36,752,518.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	953,000.00	1,922,800.00
210604	Урсгал засвар	953,000.00	1,922,800.00
2107	Томилолт, зочны зардал	1,280,032.00	1,134,000.00
210702	Дотоод албан томилолт	1,280,032.00	1,134,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		916,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		916,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,440,511.00	44,836,076.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,649,300.00	2,234,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	4,576,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	34,591,211.00	38,025,576.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,495.93	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	48,495.93	
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	48,495.93	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	11,404,148.14	13,784,158.66
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,000.19	
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	5,000.19	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-5,000.19	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	11,399,147.95	13,784,158.66

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	415,780,800.00	562,148,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,000.00	105,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	35,000.00	105,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,000.00	105,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	105,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	415,745,800.00	562,043,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	365,860,700.00	504,184,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	365,860,700.00	504,184,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	49,885,100.00	57,858,700.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49,885,100.00	57,858,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	386,077,651.78	551,959,962.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	386,077,651.78	551,959,962.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	386,029,155.85	551,959,962.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	254,446,713.24	394,614,206.80
210101	Үндсэн цалин	178,225,733.80	265,081,244.47
210102	Нэмэгдэл	66,785,883.10	117,741,317.93
210104	Урамшуулал	9,435,096.34	11,791,644.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,855,238.54	49,794,334.75
210201	Тэтгэврийн даатгал	21,710,178.60	33,955,477.87
210202	Тэтгэмжийн даатгал	2,554,073.93	3,931,967.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,025,919.13	1,966,183.81
210204	Ажилгүйдлийн даатгал	500,819.00	1,966,183.81
210205	Эрүүл мэндийн даатгал	5,064,247.88	7,974,522.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,883,604.07	56,858,700.00
210301	Гэрэл, цахилгаан	4,746,224.07	4,038,053.92
210302	Түлш, халаалт	42,720,480.00	51,264,576.00
210303	Цэвэр, бохир ус	1,416,900.00	1,556,070.08
2104	Хангамж, бараа материалын зардал		
2105	Нормативт зардал	38,453,200.00	33,412,466.00
210502	Хоол, хүнс	38,453,200.00	33,412,466.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	953,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	953,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	540,000.00	1,396,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	540,000.00	1,396,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,897,400.00	14,884,255.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,995,300.00	10,440,055.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,902,100.00	4,444,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,495.93	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	48,495.93	
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	48,495.93	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	29,703,148.22	10,188,537.45
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	29,703,148.22	10,188,537.45
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		35,660,811.06
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		45,849,348.51

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	45,018,465.80	94,997,674.00	1,332,225,720.47	1,472,241,860.27
17	Тайлант үеийн үр дүн			13,784,158.66	13,784,158.66
19	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	45,018,465.80	94,997,674.00	1,346,009,879.13	1,486,026,018.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 сарын 31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл					
71801 - сургуулийн өмнөх боловсрол					
80233 - хүүхэд хамгаалал					
1220	Тусламжийн орлого	599,700.00	599,700.00		100
122005	Төсвөөс санхүүжих	599,700.00	599,700.00		100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	599,700.00	599,700.00		100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	599,700.00	599,700.00		100
81605 - эрүүл мэндийг дэмжих					
1220	Тусламжийн орлого	1,025,600.00	1,025,600.00		100
122005	Төсвөөс санхүүжих	1,025,600.00	1,025,600.00		100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,025,600.00	1,025,600.00		100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,025,600.00	1,025,600.00		100
81807 - цэцэрлэгийн хүүхдийн хоол					
1220	Тусламжийн орлого	33,139,700.00	33,139,700.00		100
122005	Төсвөөс санхүүжих	33,139,700.00	33,139,700.00		100
2105	Нормативт зардал	34,188,600.00	33,168,450.00	1,020,150.00	97.02
210502	Хоол, хүнс	34,188,600.00	33,168,450.00	1,020,150.00	97.02
81816 - зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр					
1220	Тусламжийн орлого	2,261,800.00	2,261,800.00		100
122005	Төсвөөс санхүүжих	2,261,800.00	2,261,800.00		100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,261,800.00	2,261,800.00		100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,261,800.00	2,261,800.00		100
81823 - боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх					
1220	Тусламжийн орлого	1,025,600.00	1,025,600.00		100
122005	Төсвөөс санхүүжих	1,025,600.00	1,025,600.00		100

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,025,600.00	500,000.00	525,600.00	48.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,025,600.00	500,000.00	525,600.00	48.75
81832 - нүүдлийн бүлэгт хамруулах					
1220	Тусламжийн орлого	5,009,400.00	5,009,400.00		100
122005	Төсвөөс санхүүжих	5,009,400.00	5,009,400.00		100
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,168,000.00		3,168,000.00	
210101	Үндсэн цалин	2,574,000.00		2,574,000.00	
210102	Нэмэгдэл	594,000.00		594,000.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	126,700.00		126,700.00	
210202	Тэтгэмжийн даатгал	31,700.00		31,700.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,800.00		15,800.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	15,800.00		15,800.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	63,400.00		63,400.00	
2105	Нормативт зардал	554,400.00	244,016.00	310,384.00	44.01
210502	Хоол, хүнс	554,400.00	244,016.00	310,384.00	44.01
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	891,000.00	820,055.00	70,945.00	92.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	891,000.00	820,055.00	70,945.00	92.04
81834 - боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх					
1220	Тусламжийн орлого	457,452,500.00	457,452,500.00		100
122005	Төсвөөс санхүүжих	457,452,500.00	457,452,500.00		100
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	429,137,400.00	391,351,506.80	37,785,893.20	91.19
210101	Үндсэн цалин	283,975,300.00	251,646,067.47	32,329,232.53	88.62
210102	Нэмэгдэл	140,683,300.00	131,176,494.93	9,506,805.07	93.24
210104	Урамшуулал	4,478,800.00	8,528,944.40	4,050,144.40	190.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,804,800.00	49,386,534.75	1,418,265.25	97.21
210201	Тэтгэврийн даатгал	34,547,900.00	33,678,177.87	869,722.13	97.48
210202	Тэтгэмжийн даатгал	4,063,700.00	3,899,367.22	164,332.78	95.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,032,200.00	1,949,883.81	82,316.19	95.95
210204	Ажилгүйдлийн даатгал	2,032,200.00	1,949,883.81	82,316.19	95.95
210205	Эрүүл мэндийн даатгал	8,128,800.00	7,909,222.04	219,577.96	97.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,488,800.00	1,396,000.00	92,800.00	93.77
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,488,800.00	1,396,000.00	92,800.00	93.77
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,633,400.00	9,572,100.00	1,061,300.00	90.02

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,189,200.00	5,127,900.00	1,061,300.00	82.85
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,444,200.00	4,444,200.00		100
81835 - сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах					
1220	Тусламжийн орлого	3,670,500.00	3,670,500.00		100
122005	Төсвөөс санхүүжих	3,670,500.00	3,670,500.00		100
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,262,700.00	3,262,700.00		100
210104	Урамшуулал	3,262,700.00	3,262,700.00		100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	407,800.00	407,800.00		100
210201	Тэтгэврийн даатгал	277,300.00	277,300.00		100
210202	Тэтгэмжийн даатгал	32,600.00	32,600.00		100
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,300.00	16,300.00		100
210204	Ажилгүйдлийн даатгал	16,300.00	16,300.00		100
210205	Эрүүл мэндийн даатгал	65,300.00	65,300.00		100
81844 - гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах					
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	105,000.00	105,000.00		100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	105,000.00	105,000.00		100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	105,000.00	105,000.00		100
Бусад эх үүсвэр					
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			35,660,811.06	35,660,811.06	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			45,849,348.51	45,849,348.51	
Төсвийн бусад мэдээллийн ангилал					
БАЙГУУЛЛАГЫН ТОО		1	1		100
Төсвийн байгууллага		1	1		100
АЖИЛЛАГСАДЫН ТОО		15.5	18.5	-3	119.35
Удирдах ажилтан		1	1		100
Гүйцэтгэх ажилтан		5	6.5	-1.5	130
Үйлчлэх ажилтан		9	11	-2	122.22
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)		100	82	18	82

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 сарын 31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл					
71801 - сургуулийн өмнөх боловсрол					
80109	тэтгэврийн байгууллагуудын төгтмөл зардал				

1220	Тусламжийн орлого	57,858,700.00	57,858,700.00		100
122005	Төсвөөс санхүүжих	57,858,700.00	57,858,700.00		100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,858,700.00	56,858,700.00		100
210301	Гэрэл, цахилгаан	4,669,400.00	4,038,053.92	631,346.08	86.48
210302	Түлш, халаалт	50,689,300.00	51,264,576.00	575,276.00	101.13
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,556,070.08	-56,070.08	103.74
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00		100
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00		100

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завхан аймгийн Шилүүстэй сумын хүүхдийн цэцэрлэгийн чиглэл:

Цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын зорилго, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхдийг асрах, хамгаалах, тэдний хөгжил, төлөвшлийг дэмжсэн цогц үйл ажиллагаа эрхэлнэ.

Завхан аймгийн Шилүүстэй сумын хүүхдийн цэцэрлэгийн зорилго:

Завхан аймгийн Шилүүстэй сумын хүүхдийн цэцэрлэг нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэх, суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэх зорилготой үйл ажиллагаагаа явуулж байгаа Боловсрол Шинжлэх Ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 37 арга хэмжээ төлөвлөснөөс 94 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Завхан аймгийн Шилүүстэй сумын хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
2. Боловсролын ерөнхий хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
10. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
11. Хөдөлмөрийн тухай хууль
12. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй бөгөөд “төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай”, “орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай”, “цэцэрлэгийн хүүхдийн хоолны нэг өдрийн зардлын хэмжээг нэмэгдүүлэх” зэрэг Засгийн газрын тогоолуудад өөрчлөлт орсон байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл

ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Тус цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжгүй бөгөөд Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн ажилтан төрийн сангийн мэргэжилтэн нар хяналт тавин ажиллаж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Шилүүстэй сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан аймгийн Шилүүстэй сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 14,491.6 мянган төгрөгөөр буюу 0.98 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	35,660.8	45,849.3	10,188.5
Авлага	0	0	0
Бараа материал	40,639.9	48,886.9	8,247.0
Үндсэн хөрөнгө	1,389,348.1	1,385,734.2	-3,613.9
Нийт хөрөнгө	1,472,241.9	1,486,733.5	14,491.6
Өр төлбөрийн дүн	0	707.4	-707.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,472,241.9	1,486,026.0	13,784.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,472,241.9	1,486,733.5	14,491.6

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант онд:

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 10,188.5 мянган төгрөгөөр, бараа материал 8,247.0 мянган төгрөгөөр өссөн бол үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 3,613.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Тус цэцэрлэг нь оны эхэнд 40,639.9 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд төсвийн хөрөнгөөр 45,349.3 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан бол 11,220.3 мянган төгрөгийн хүнсний болон бусад хангамжийн

материалыг хандив тусламжаар хүлээн авч 45,739.2 мянган төгрөгийн зарцуулалт хийж, 2,583.5 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар акталж, устгасан байна. Оны эцэст 48,886.9 мянган төгрөгийн бараа материалыг тоолж, тооллогын бүртгэл хөтөлж, тооцоог бодсон байна. Үндсэн хөрөнгийн хувьд 34,081.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, хүүхдийн тоглоомын талбайг хандив тусламжаар орлогот авч бүртгэлд тусгажээ. Тайлант онд 38,025.6 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна.

Тайлант оны эцэст авлага үүсгээгүй бөгөөд нийгмийн даатгалын байгууллагад 707.4 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар батлагдсан "төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай", "орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай" 82, 128 дугаар тогтоолуудын дагуу ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл нэмэгдэж, төсвийг тодотгосноор тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс мянган төгрөгөөр, нийт мянган төгрөг, зардлыг мянган төгрөг байхаар тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн, батлуулж ажилласан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын болон орон нутгийн төсвөөс 562,043.5 мянган төгрөгийг санхүүжүүлж, туслах үйл ажиллагааны орлогоос 105.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 551,959.9 мянган төгрөг буюу 91.3 хувьтай байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 40,953.9 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 1,330.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 92.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,762.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
71801	Сургуулийн өмнөх боловсрол	597,914.3	551,959.9	45,954.3	92.3
80233	Хүүхэд хамгааллын зардал	599.7	599.7	0	100
81605	Эрүүл мэндийг дэмжих зардал	1,025.6	1,025.6	0	100
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал	34,188.6	33,168.4	1,020.2	97.1
81816	Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	2,261.8	2,261.8	0	100
81823	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх зардал	1,025.6	500.0	525.6	48.8
81832	Нүүдлийн бүлэгт хамруулах	4,740.1	1,064.1	3,676.0	22.4

81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал	492.064.4	451.706.1	40,58.3	91.8
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардал	3,670.5	3,670.5	0	100
81844	Төвлөрсөн болон гүнзгийрүүлсэн	105.0	105.0	0	100
Дүн		540,055.6	494,101.2	459,54.4	92.3
Орон нутгийн төсвөөс санхүүжих					
80109	Тогтмол зардал	57,858.7	57,858.7	0	100
Нийт дүн		597,914.3	551,959.9	45,954.3	92.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 57,858.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, байр ашиглалттай холбоотой зардалд 56,858.7 мянган төгрөг, урсгал засварын зардалд 1,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, дээд шатны байгууллагад мөнгө төвлөрүүлээгүй байна.

Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
	Цагаантуурай ХХК тендер шалгаруулалт	Хүүхдийн хоолны материал	9,942.0	9,942.0
2	Шууд гэрээ / иргэд, аж ахуйн нэгжүүд/	Хүүхдийн хоолны материал	24,801.0	23,470.5
ДҮН			34,743.0	33,412.5

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно. Сумын засаг даргын тамгын газарт хүүхдийн хоолны 6 багцад тендер зарлаж, оролцсон аж ахуйн нэгжүүдээс Цагаанчулуут сумын Цагаантуурайт ХХК шалгарч цэцэрлэгийн эрхлэгчтэй гэрээ байгуулан ажилласан бөгөөд гэрээ байгуулсан аж ахуйн нэгжтэй оны эцэст тооцоо нийлж, өглөг, авлагагүй гэдгээ баталгаажуулж, баримтжуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Завхан аймгийн Шилүүстэй сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ний аудитор Р.Мядагмаа хийж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, төргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Шилүүстэй сумын хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 382,530.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцож, 5,737.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75,0 хувь буюу 4,303.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг түвшинг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завхан аймгийн Шилүүстэй сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан тул акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байгаагүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 644.1 мянган төгрөгийн алдаа илэрч, 644.1 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт: тогтоогоогүй

5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж:

1. Хүүхдийн хоолны нормативыг сар бүр мөрдөж ажиллаагүйгээс 644.1 мянган төгрөгийн зөрүү гарсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" заалт, Засгийн газрын 2019 оны 450, 2024 оны 237 дугаар тогтоолуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн байдал: Хоолны нормативыг мөрдөж ажиллах, сар бүр хяналтыг хэрэгжүүлэх талаар зөвлөмж өглөө.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхилдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Зөвлөмж	
							Тоо	Дүн	Тоо	Дүн

/Мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуллага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад цийлжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бүлгийн багш нарын ирцийн бүртгэлээс эд хариуцагчийн хоолны зарцуулалтын тайланд бичигдсэн хуухдийн тоо 2-42 хуухдээр зөрсөн бөгөөд хуухдийн хоолны нормативыг сар бүр мөрдөж ажиглаагүйгээс хоолны зардлыг 2024 оны 1, 9 дүгээр саруудад 154 749 төгрөгөөр дутуу, 2-12 дугаар саруудад 489 323 төгрөгөөр илүү зарлагдсан нь	1	644,1					1	644,1				

Үүнээс

/Мянган төгрөгөөр/

